



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/59

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутаг, брэнд бүтээгдэхүүнийг сурталчилан таниулах, аймгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн, алдартан, гавьяатнуудыг алдаршуулах зорилгоор Монголын Үндэсний олон нийтийн радио телевизээс улсын хэмжээнд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Монгол түмний мэнд” нэвтрүүлэгт оролцох зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 5,309,500 (таван сая гурван зуун есөн мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орон гүйцэтгэгч Ц.Батзоригт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20<sup>22</sup> оны  
01 дугаар сарын 28-ны өдрийн 159 дугаар  
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шаардлагатай зүйлс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Монгол түмний мэнд нэвтрүүлэг (оролцоо)-ийн төлбөр		1	4,500,000	4,500,000
2	Нэвтрүүлгийн сюжетийн төлбөр		1	300,000	300,000
3	Гар ариутгагч	ширхэг	1	6500	6500
4	Нэг удаагийн таваг	Боодол	1	13000	13000
5	Ингэний хоормог	литр	20	10000	200,000
6	Шинжилгээний тест (Ковид)	ширхэг	20	14500	290,000
Нийт үнэ					5,309,500

\_\_оОо\_\_